

**АНУ-ЯПОНЫ ЦЭРГИЙН ТҮНШЛЭЛИЙН
ГОЛ ЗОРИЛГО****О.Оюунгэрэл**

Цэргийн хүчийг гадаад улс төрийн бодлогынхоо гол хэрэглүүр болгох явдал империалист гүрнүүдийн гадаад бодлогын түрэмгий чиг шугам, тэдгээрийн практик үйл ажиллагаанд үлэмж их нөлөөлж ирсэн хүчин зүйл юм.

Америкийн засаг захиргааны өнөөгийн улс төрийн чиг шугамын түрэмгий шинж нь түүнээс дэлхийн янз бүрийн районд, тухайлбал Ази, Алс Дорнодод явуулж байгаа бодлогоос нь тодорхой харагдаж байна.

Дэлхийн II дайны дараа, бүр 40-өөд оны сүүлчээр АНУ Азид социализмын байр суурийн бэхжилт, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтийг газар авахуулахгүйн тулд Японд хандах хандлагаа эрс өөрчилсөн юм. Тэр үед АНУ тус тивд Америкийн империализмын байр суурийг батжуулах зорилгоор “Азид явуулах шинэ улс төрийн бодлого” гэгчийг боловсруулсан билээ. Түүндээ АНУ-ын эрх баригч бүлгийнхэн Японыг цэрэг улс төрийнхөө холбоотон байх бололцоотой, шаардлага хангах хүч чадалтай гэж үзжээ. Мөн Япон улс ч Америкийн империализмаас Солонгост дэгдээсэн дайнд (1949-1953) уг бүс нутаг дахь түүний цэрэг дайны үйл ажиллагааг хангаж стратегийн чухал бааз болж чадахаа харуулахыг оролдсон юм. 50-иад оноос эхлэн Японы газар нутагт АНУ цэргийн баазын тоогоо эрс олшруулж японы зэвсэгт хүчийг сэргээх чиг бодлогыг хэрэгжүүлэх болжээ. Энэ нь юуны өмнө тус нутагт капиталист нийгмийг хадгалан барьж, онцгой үед олон нийтийн ардчилсан хөдөлгөөнийг нухчин дарж чадахуйц зэвсэгт хүчийг байгуулах гэсэн гол зорилгод чиглэгджээ.

60-аад оны үед Японы эдийн засаг хурдацтай хөгжсөн нь Японд цэрэг-улс төрийн чиг шугамыг боловсруулахад тодорхой нөлөө үзүүлэв. Өсөн нэмэгдэж байсан эдийн засгийн болон “батлан хамгаалах хүчинд” тулгуурлан японы эрх баригч бүлгийнхэн 1960 оны 1-р сард АНУ-тай хамтран ажиллах, “аюулгүйн гэрээ” гэгчид гарын үсэг зуржээ.¹ Ийнхүү хөгжингүй капиталист орны нэг АНУ-тай Японы тогтоосон цэрэг-улс төрийн холбоо нь юуны өмнө ЗХУ, Азийн аюулгүй байдлын эсрэг чиглэж Азид энх тайван, социализмын байр суурь улам батжин хүчирхэгжиж байгааг харгалзан, АНУ ба Японы эрх баригч бүлгийнхний хүч чармайлтыг нэгтгэн, капитализмын байр суурийг бэхжүүлэхэд зориулагдсан байна.

¹ С.И.Вербицкий. Японо-американский военно-политический союз. М., 1972: с.26-48.

Японы эрх баригчдын цэрэг дайны бодлого нь империалист шинж агуулснаас гадна дэлхийн капитализмын байр суурь, юуны өмнө түүний цэргийн хүчийг улам нэмэгдүүлэн цэргийн хүчин чадлын зохих нөлөөний тусламжаар олон улсын тавцан дээр Японы гадаад улс төрийн байр суурийг бэхжүүлэх зорилготой юм.

Япон-Америкийн гэрээний хүрээнд Японы роль өсөн нэмэгдэж, тус улсын эдийн засгийн хүч чадал нэмэгдэж, өнөөгийн Японы арми нь урьдын эзэн хааны армиас хүч чадлаар хэд дахин давуу орчин үеийн хүчирхэг зэвсэг техникээр хангагдсан явдал нь шинэ нөхцөлд цэрэг-улс төрийн бодлогыг боловсруулах, эрх баригч бүлгийнхний дотор милитарист үзэл санааг улам хүчтэй болгох зэрэгт нөлөөлжээ.

70-аад оны эхээр Япон нь “өөрийгөө батлан хамгаалах программ” гэгчийн хүрээнд зэвсэгт хүчнийхээ хүч чадлыг чанарын хувьд цаашид сайжруулан нэмэгдүүлэх, цэрэг дайны асуудлыг бие дааж шийдвэрлэх стратеги, тактикийг боловсруулж байв. Гэвч 70-аад оны дундуур Энэтхэг-Хятадын хойгт эх оронч, үндэсний эрх чөлөөний хүчин ялж, Өмнөд Вьетнам, Лаос, Кампучи зэрэг орон империалист ноёрхлыг таягдан хаясан явдал нь Японд цочрол өгчээ. Ийм нөхцөл байдалд юуны өмнө Япон-Америкийн монопольт хөрөнгөтнүүдийн ангийн ашиг сонирхол нийлж, Японы “өөрийгөө батлан хамгаалах” эрх хэмжээ чамлагдах болжээ.

Энэтхэг-Хятадын хойг дахь империалист хүчний ялагдал Азид Америкийн нөлөөг багасгаж тус бүс нутагт явуулах Америкийн бодлогод төдийгүй, мөн Японы эрх баригч бүлгийнхний чиг шугамд ч цохилт болсон юм. Энэ үеэс эхлэн хоёр орны хоорондох “аюулгүйн гэрээний системийг бэхжүүлэх явдал Америкийн улс төрийн бодлогын гол чиг хандлагын нэг болж, Япон улс нь Ази дахь АНУ-ын хамгийн чухал холбоотон гэж тооцогдох болжээ. Хоёр орон цэргийн бодлогоо нягт уялдуулан явуулахын тулд 1976 онд Токиод АНУ-ын батлан хамгаалах яамны сайд агсан Шлессинджертай хийсэн хэлэлцээний үед “Батлан хамгаалах талаар хамтран ажиллах Япон-Америкийн хороо” хэмээх шинэ зөвлөлдөх газрыг байгуулахаар тохиролцжээ.² Японыг цэргийн чадамжаа нэмэгдүүлж, “батлан хамгаалах” хүчээ зузаатгах талаар АНУ-аас тавьж буй шаардлага нь Японыг АНУ-ын цэрэг-стратегийн нөлөөнд улам гүнзгий хамруулах гэсэн бодлого юм. Үүний дагуу Японы эрх баригч бүлгийнхэн юуны өмнө тэнгисийн цэргийн хүчин чадлаа нэмэгдүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж эхэлсэн билээ.

АНУ-аас Японы талаар явуулж буй бодлого, Японд үзүүлж буй шахалт дарамт нь юуны өмнө ЗХУ-д цэргийн заналхийлэл учруулах гэсэн оролдлоготой нягт холбоотой юм. Эрх баригч Либерал-ардчилсан намын удирдлага бол Японы засгийн газар нь Японы зэвсэгт хүчний хүч чадлыг цаашид улам эрчимжүүлэх, Үндэсний батлан хамгаалах газар (ҮБХГ), Пентагон хоёрын холбоог бэхжүүлэх талаар илт ажиллаж ирсний зэрэгцээ Японд милитарист программыг хэрэгжүүлэхэд аль болох таатай нөхцөлийг бүрдүүлэхийг хичээж байна. Энэ нь энх тайванч агуулгатай Үндсэн хууль болон бусад гол хууль тогтоомж руу дайран давшлах, Японд милитаризмыг сэргээх үзэл санааг дэвэргэн сурталчлах, америк-японы хамтарсан зэвсэгт хүчний цэргийн хээрийн томоохон сургуулиудыг хийж байгаа зэрэг баримтаар илэрч байна. Ийм ажил явууллага нь Японы Үндсэн хуулийн

² “Япония-1976”, М., 1977, с , 43.

энх тайванч зарчмыг бүдүүлгээр зөрчиж байгаа төдийгүй, Японы ард түмний язгуур эрх ашиг, Ази болон Алс Дорнодод энх тайван, сайн хөршийн харилцааг тогтоон хөгжүүлэх гэсэн улс түмний эрмэлзлэлд эрс харшилж байна.

70-аад оны сүүлч 80-аад оны эхээр Японд Америкийн империализмын харгис чиг шугамын нөлөө ихэсч, мөн тус орны үндсэрхэг, хонзогногч хандлага хүчтэй болсны улмаас Япон дахь милитарист хүчний талынхан мэдэгдэхүйц идэвхжиж байна.

Японы “өөрийгөө батлан хамгаалах хүч” орчин үеийн зэвсэг техникээр бүрэн хангагдаж, түүний байлдааны бэлтгэл нь урьд өмнө байгаагүй түвшинд хүрээд байхад японы цэргийн эрхтнүүд болон хөрөнгөтний зарим улс төр судлаачид тус орны зэвсэгт хүчийг чанарын хувьд цаашид улам бэхжүүлэн нэмэгдүүлэх хэрэгтэйг нотлохыг оролдож байна.

Японы цэргийн зардлын одоогийн болон цаашдын хэмжээ нь улам бүр нэмэгдсээр байна. 1976 онд тогтоосон армид зориулах зардал нь ойрын жилүүдэд үндэсний нийт бүтээгдэхүүний нэг хувиас давж, 80-аад оны сүүлч гэхэд үндэсний нийт бүтээгдэхүүний хоёр хувийг эзлэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл Япон нь цэргийн зардлаар капиталист гүрнүүдээс АНУ-ын дараа II байранд орж Өрнөд Герман, Англи, Франц зэрэг орныг гүйцэж түрүүлэх тухай хэвлэлийн мэдээлэлд дурджээ.

Япон-Америкийн “аюулгүй гэрээ”-ний заалтын дагуу Японы арлууд дахь баазууд нь үнэн хэрэгтээ АНУ-ын зэвсэгт хүчинд бүрэн харьяалагдаж байна. Тухайлбал: Иванкуни болон Окинава арлын төв хэсэг дэх Футама зэрэг баазад цөмийн зэвсэг байрлуулсан нь Японы үндсэн хуульд “цөмийн зэвсэггүй байх” тухай заасан зүйлд эрс харшилж байна. Америкийн тэнгисийн цэргийн хүчний томоохон бааз Иокосука нь АНУ-ын хилийн чанадад буй Америкийн нисэх онгоц тээгч хөлөг онгоцуудыг байрлуулах зориулалттай чухал усан боомт болж хувирчээ. Сүүлийн үед Иокосукад “Поллак”, “Танни” зэрэг Америкийн атомын шумбагч хөлөг онгоцууд байнга орж гарах болов. АНУ-ын стратегийн нисэх хүчнийг цөмийн дайнд бэлтгэх томоохон цэг нь Иокота болж байгаа бөгөөд Мисава бааз нь Америкийн агаарын цэргийн хүчний цөмийн дайралтын анхны талбар болж байна. Одоо АНУ-ын батлан хамгаалах яамны Японы боомтод байрлуулсан Номхон далай дахь Америкийн тэнгисийн цэргийн хүчний хөлөг онгоцуудыг “Томогавк” гэдэг цөмийн далавчит пуужингаар зэвсэглэх шийдвэр гарган, түүнийгээ хэрэгжүүлж эхэлж байна.

Окинава арлын газар нутгийн 20 хувийг Америкийн цэргийн барилга байгууламж эзэлжээ. Хэрэв 70-аад оны дунд үе хүртэл эдгээр барилга байгууламжид АНУ-ын хуурай замын цэргийн ангиуд байрлаж байсан бол одоо тэнгисийн болон агаарын цэргийн хүчнийг төвлөрүүлэх хандлагатай болж байна.

Албан ёсны мэдээнээс үзвэл, либерал-ардчилсан намын засгийн газар өөрийн нутаг дэвсгэрт АНУ-ын зэвсэгт хүчнийг байрлуулж, түүнд жил тутам миллиард гаруй доллар зарцуулж байна. Зөвхөн Америкийн цэргийн нэг албан хаагчид Японоос гарч буй зардал нь 21700 долларт хүрч байна.³ Гэтэл Японы хамгийн чухал асуудал болох хүн амын боловсрол, орон сууцны барилга байгууламжид

³ Международная жизнь” 1983, № 11, с 100

зориулах зардал эрс буурч байгаа бөгөөд харин Пентагоны офицеруудын шинэ байр, цэргийн хуаранг барьж байгуулахад японы эрх баригчид хөрөнгө мөнгийг хайрлахгүй зарж байна.

Японы милитаристууд АНУ-ын эрх баригч бүлгийнхний цэргийн түншлэл нь Токиод хэвлэгдэн гарсан “1983 оны батлан хамгаалах асуудлын талаарх Цагаан ном”-д тод тусгагджээ. Үүнд анх удаа Японы цэргийн хүчийг бэхжүүлэх явдлыг Өрнөдийн цэргийн ерөнхий стратегийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзсэн байна.

Япон улс цэрэг зэвсгээ ийнхүү нэмэгдүүлж, АНУ болон бусад орны харгис хүчинтэй цэргийн холбоо сүлбээгээ бэхжүүлэн, цэрэг дайны бэлтгэл хийж байгаа нь Ази, Номхон далайн бүс нутгаар үл барам дэлхий дахины улс түмний энх тайван, аюулгүй байдалд аюултай алхам болж байна.

Сүүлийн үед Вашингтоны ерөнхий стратегид Токио улам бүр татагдан орж байгаа нь мэдэгдэхүйц болж, Вашингтоныхон ч АНУ-Японы холбоог Ази дахь цэргийн хүчний амин чухал зүйл гэж илт мэдэгдэж байна.

АНУ-ын чиг бодлого нь империалист улсуудын хүч бололцоог дээд зэргээр төвлөрүүлэн ашиглаж, ЗХУ-аас цэрэг-стратегийн хувьд давуутай болохыг эрмэлзэн, “Ази болон Номхон далайн бүс нутагт АНУ-ын онцгой үүрэг ролийг сэргээх”⁴ гэсэн зорилгыг агуулж байгаад оршино.

Өнөөгийн АНУ-ын засаг захиргаа цэрэг стратегийн зорилгоо хэрэгжүүлэхэд бүх практик ажиллагаагаа чиглүүлж байгаа бөгөөд үүний нэг нь “Рейганы Азид явуулах шинэ стратегийн бодлого” гэгч юм. Энэ нь Азид АНУ-ын байр суурийг хүчтэй болгож, дэвшилт хандлагыг таслан зогсоох, социалист орнуудын нөлөө тусламжийг оруулахгүй байхад чиглэж байна.

АНУ-аас Япон, Өмнөд солонгостой тогтоосон цэргийн эвсэл холбоо нь Азид цэрэг-улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх гол тулгуур болж байна.

Сүүлийн жилүүдэд АНУ-аас Алс Дорнодын районд хийж буй цэргийн сургууль нь агаар, ус, хуурай газраар түрэмгийлэн довтлох бэлтгэлээ хангахад чиглэж, түүний цар хүрээ нь улам өргөн хэмжээтэй болж байна. 1985 оны намар Өмнөд солонгосын нутагт америк-өмнөд солонгосын цэргийн “Тим Спирит-85” зэрэг хамтарсан хээрийн томоохон сургуулиудыг цэрэг, зэвсгийн хүчээр сүрдүүлэх үүднээс хийв. Эдгээр нь Токио-Вашингтон-Сеулын хоорондын милитарист холбоо улам бэхжиж байгаагийн бас нэг нотолгоо билээ.

Эдгээр хээрийн сургууль нь империалист дайнч хүчний аюултай өдөөн хатгалга бөгөөд юуны өмнө БНАСАУ, цаашилбал Ази, Алс Дорнодын бүс нутгийн бусад улс түмний энх тайван, аюулгүй байдалд ноцтой аюул учруулж байна.

Нөхөр Ж.Батмөнх Монгол-Болгарын найрамдлын цуглаан дээр хэлсэн үгэндээ: “АНУ Ази тивд байрлуулсан цэргийн хүчээ улам зузаатгаж, энэ тивийн өргөн уудам газар нутгийн цөмийн дайны талбар болгохоор санаархаж байна. АНУ Японы милитаризмыг сэргээх явдлыг элдвээр өөгшүүлж, Алс Дорнодод цэргийн томоохон эвслийн гол цөм болгох зорилгоор Япон, Өмнөд солонгостой цэрэг-улс төрийн холбоо байгуулж байна”⁵ гэж тэмдэглэсэн билээ.

⁵ “Правда”. 1982. IV. 24

⁶ “Үнэн” 1985. VI.5.

АНУ өөрийн холбоотон Японыг цэрэг-дайны түрэмгий ажиллагаандаа татан оруулж, алс Дорнодод байгуулсан Вашингтон-Токио-Сеулын цэргийн эвсэл холбоондоо улам их анхаарч байна. 1983 оны сүүлчээр АНУ-ын ерөнхийлөгч Р.Рейганаас алс Дорнодын Япон, Өмнөд Солонгост хийсэн айлчлалын зорилго нь Японыг Өмнөд Европын НАТО-гийн гишүүн орнуудын нэгэн адил бие даасан үүрэг авахуулах, Токио-Сеулын хоорондын цэргийн шууд хэлхээ холбоог идэвхжүүлэх явдал байв. АНУ-ын засаг захиргааны цэрэг-дайны энэ төлөвлөгөөнд Японы ерөнхий сайд Я.Накасонэ, Өмнөд Солонгосын Чон Ду Хваны тоглоомын дэглэм ч их идэвхтэй дэмжлэг үзүүлж байна.

1984 онд Япон цэргийн зардлаа 6.6% (29 трилл.иен) хүртэл нэмэгдүүлж АНУ-аас сөнөөгч “Ф-15” нисэх онгоц 21, хөлөг онгоц эсэргүүцэх “Р-3С” нисэх онгоц 11, эскадрын мина тээгч хөлөг онгоц болон орчин үеийн зэвсэг, техникийг голлон авахыг зорьж байна. Японы цэргийн эрхтнүүд шинэ таван жилд (1986-1990 онд) зэвсэгт хүчнээ өргөтгөх төлөвлөгөөний үндсэн зарчмуудыг боловсруулах ажилд ороод байна. Энэ нь тус орны цэргийн хүч чадлыг эрс нэмэгдүүлэх, агаарын болон тэнгисийн цэргийн хүчний нөлөөний хүрээг өргөтгөхөд чиглэхээс⁶ гадна Америк-Японы цэрэг зэвсгийн түншийн холбоог цаашид улам гүнзгийрүүлнэ гэсэн үг юм.

Японд ийнхүү милитаризм сэргэж байгаа нь Япон-Америкийн цэргийн түншлэлтэй нягт холбоотой юм.⁷ АНУ-ын дайнч бүлгийнхэн Японоос “өөрийгөө батлан хамгаалах хүчний” байлдааны чадлыг чанарын хувьд цаашид сайжруулан нэмэгдүүлэхийг шаардахын зэрэгцээ Японтой хийсэн үлэмж хэмжээний худалдааны алдагдлаа (1982 онд 20 млрд.доллар) багасгаж, улмаар дэлхийн зах зээлд гол өрсөлдөгч болох түншийнхээ хүч чадлыг сулруулахыг оролдож байна.

Японы эрх баригчид “бүх талын аюулгүй байдал” гэгч системийг байгуулан, Азид цэрэг-улс төр, эдийн засгийн талаар Японы ноёрхлыг тогтоохыг бас зорьж байна.⁸

Токио Вашингтоны нэг адил милитарист чиг шугамаа булзайруулан цагаатгахын тул “зөвлөлтийн аюул” гэгчээр халхавчлан шалтаглаж байна. Сүүлийн үед Японы эрх баригчид Зөвлөлтийн эсрэг Рейганы засаг захиргааны дэгдээж буй кампанийг дэмжин, зөвлөлтийн дунд тусгалын пуужинг Азийн хэсэгт байрлуулах хариу арга хэмжээний тухай ЗХУ-ын шийдвэрийг зохисгүй гэж тэмдэглэн, Зөвлөлтийн эсрэг сэтгэл зүйн дайны кампанит ажлыг дэгдээж байна. Ерөнхий сайд Я.Накасонэ энэ онд Боннд болсон капиталист 7 гүрний удирдагчдын ээлжит зөвлөлгөөн дээр Вашингтоны “стратегийн батлан хамгаалах санаачлагыг зөвшөөрч, “оддыг дайн” энэ программыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэдгээ мэдэгджээ.⁹

Японы дайнч бүлгийнхэн “зөвлөлтийн аюул” гэгч үндэсгүй зүйлийг шүүрэн авч, ЗХУ, Японы хоорондын хэвийн харилцаанд сэв суулгах гүжир гүтгэлгийг явуулсаар байна.

Ерөнхий сайд Накасонэ үнэн хэрэгтээ өөрийн орны бодлогыг Зөвлөлтийн эсрэг чиглэсэн НАТО-гийн цөмийн стратегид зохицуулан явуулж байна. Үүнээс үзэхэд Америк-Японы харилцаа нь улам бүр цэрэг-улс төрийн шинжтэй болж, Ази болон дэлхийн бусад бүс нутаг дахь олон улсын байдлыг хурцдуулахад хүргэж байна.

⁶ “Үнэн” 1984. III. 31

⁷ В.М.Мазуров. США-Китай-Япония. 1969-1979. М., 1980,

⁸ “Проблемы Дальнего Востока”. 1983. № 4, стр 20

⁹ “Правда”. 1985. VII.9

Японы милитаризм сэргэж, АНУ-тай тогтоосон цэргийн хэлхээ холбоог цаашид бэхжүүлэх гэсэн Японы эрх баригч бүлгийнхний харгис чиг бодлогыг Японы дэвшилт олон нийт Азийн энхийг эрхэмлэгч бүх улс түмний хамт эрс шийдвэртэй эсэргүүцэн тэмцэж байна. Японы “Токио симбун” сонин бичихдээ Япон улс дайн дажингүй энх амгалан байж, ЗХУ-ыг хүчээр сөрөх гэж оролдож байгаа АНУ-ын стратегийн бодлогод үг дуугүй хөтлөгдөн явах ёсгүй гэж тэмдэглэжээ.

Эд бүхнээс үзэхэд 80-аад оны Японы засгийн газрын гадаад бодлогын үйл ажиллагаа нь олон улсын хурцадмал байдлыг намжаах арга замыг хайхад чиглэсэн биш, харин дэлхийн янз бүрийн районд Японы монополийн байр суурийг бэхжүүлэх, Ази болон Номхон далайн бүс нутаг дахь Америкийн стратегид идэвхтэй оролцоход чиглэж байна. Эдгээр нь энх тайвны эрх ашиг, улс түмний аюулгүй байдалд эрс харшилж байна.

МАХН-ын Төв Хорооны Х бүгд хурал дээр нөхөр Ж.Батмөнх хэлсэн үгэндээ “Дэлхийн хамгийн уудам, олон хүн амтай Ази тивийн аюулгүй байдлыг энэ бүс нутгийн бүх улсын хүч чармайлтыг нэгтгэх, бат бэх энх тайван, тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга замыг хамтран эрж хайх үндсэн дээр л бэхжүүлж болох юм”¹⁰ гэж онцлон тэмдэглэсэн билээ.

БНМАУ Азийн аюулгүй байдлын асуудлаар Азийн орнуудын хүч чармайлтыг нэгтгэх боломжийг эрж хайх, нийт Азийн уулзалтыг зохион явуулахад хүрэх арга замыг бодож олох талаар ЗСБНХУ-ын дэвшүүлсэн оновчтой саналуудыг бүрэн дүүрэн сайшаан дэмжиж, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө хүч чармайлт гарган ажиллаж байна.

АМЕРИКАНО-ЯПОНСКОЕ ВОЕННОЕ ПАРТНЕРСТВО, ЕГО ОСНОВНАЯ ЦЕЛЬ

Резюме

Агрессивный внешнеполитический курс американской администрации носит глобальный характер. Азиатскому континенту в агрессивных военно-политических планах США отводится весьма важная роль. Одной из стратегических целей, которой подчинена деятельность администрации Рейгана, является задача: добиться усиления позиций США в Азии; не допустить укрепления прогрессивных тенденции на азиатском континенте; подорвать воздействия социалистических стран на позитивные изменения в Азии.

После поражения в Индокитае американский империализм не отказался от планов проникновения в районы Азии и Тихого Океана.

В последнее время происходит интерсивное наращивание военного присутствия США в азиатском регионе, здесь создаются все новые американские военные базы. На дальнем Востоке планируется создание крупно-масштабной военной структуры, стержнем которой будет служить “треугольник”: Вашингтон-Токио-Сеул.

¹⁰ МАХН-ын ТХ-ны Х бүгд хурал: УБ, 1985, 41-р тал

Под все усиливающимся нажимом США все более проявляется милитаристская направленность в политике правящих кругов Японии. Она все активнее участвует в стратегических планах американской администрации в отношении Азиатско-Тихоокеанского региона.

Несколько лет назад отношения между Вашингтоном и Токио были впервые официально охарактеризовали как "союз", а с тех пор все нагляднее проявляется стремление правящих кругов США приравнять американо-японский "договор безопасности" к Северо-Атлантическому пакту и таким образом возложить такие же военные обязательства, что и западноевропейским членам НАТО.

Налицо дальнейшее втягивание Токио в глобальную стратегию Вашингтона. Очевидно, что американо-японский военный союз направлен, прежде всего против безопасности СССР и других социалистических стран Азии, а также против национально-освободительного движения народов этого континента. Интенсивно вооружается южнокорейский режим, сколачивается милитаристский "треугольник": Вашингтон-Токио-Сеул, который является собой звеном в процессе создания называемой американо-японской "систем безопасности".

Милитаристская политика США и Японии в Азии, в частности на Дальнем Востоке - серьезная угроза миру и безопасности народов Азии и всего мира.

Конструктивные инициативы, миролюбивая политика СССР, МНР и других миролюбивых стран по вопросам мира и безопасности в Азии еще раз подтверждают, что они полностью соответствуют глубоким чаяниям и корейным интересам всего человечества.